



Хэвлэлийн мэдээлэл №о. 18/113
ШУУД ТҮГЭЭХ
2018 оны 3-р сарын 28

Олон улсын валютын сан
Вашингтон, Д.С. 20431 АНУ

ОУВС-ын Захирлуудын зөвлөл нь Монгол улсын Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрийн хэрэгжилтийн гурав дахь үнэлгээгээ дуусгаж, 30.55 сая ам.долларын санхүүжилтийг баталлаа.

- Эдийн засгийн өсөлт сайн, төсвийн гол үзүүлэлтүүд болон гадаад валютын нөөц давж биелснээр Монголын эдийн засаг төсөөлж байснаас илүү сайн сэргэж байна.
- Үүний зэрэгцээ хөтөлбөрийн хүрээнд хийгдэх бүтцийн шинэчлэлд зарим нэг удаашрал, ухралт гарсан байна.
- Өрийн хэмжээ өндөр байгаа, эдийн засаг нь дэлхийн таваарын зах зээлээс хамааралтайн хувьд эрх баригчид нь энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлэх хатуу байр сууриндаа тууштай байх нь туйлын чухал юм.

Олон улсын валютын сан (ОУВС)-гийн Захирлуудын зөвлөл нь Монгол улсын Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр (ӨСХ)-ийн хүрээнд гурван жилийн хугацаанд тохирсон арга хэмжээний хэрэгжилтийн гурав дахь үнэлгээг 2018 ны 3-р сарын 28-ны өдөр хийж дууслаа. Үүний үр дүнд Монгол улс нь 20.9598сая ЗТЭ (ойролцоогоор 30.55 сая ам.доллар) –ын санхүүжилт нэмж авах боломжтой болж, ингэснээр хөтөлбөрийн хүрээнд нийтдээ 104.8278 сая ЗТЭ (ойролцоогор US\$ 152.79 сая ам.доллар)-ын санхүүжилт олгогдож байна.

Монгол улсын хөтөлбөрийн хэрэгжилт маш сайн явагдаж байна. Эдийн засаг төсөөлж байснаас илүү сэргэж, 2017 онд ДНБ-ны бодит өсөлт 5.1 хувьд хүрч, төсвийн тэнцэл ДНБ-ны 15 нэгж хувиар эрс сайжирсан. Бодлогын хэрэгжилт тууштай, гадаад орчин тааламжтай байсны үр дүнд хөтөлбөрийн хүрээнд 2017 оны 12-сарын эцэст хангасан байх бүх зорилгод тоон үзүүлэлтүүд давж биелжээ. Гэхдээ бүтцийн шинэчлэлийн хувьд бүтцийн жишиг үзүүлэлтүүд дээр зарим нэг удаашрал, өмнөх үнэлгээний үед хэлэлцэгдсэн төсвийн гурван үзүүлэлтээр ухралт гарсан байна.

Монгол улсад хэрэгжүүлж буй гурван жилийн хугацаатай өргөтгөсөн хөтөлбөр нь 2017 оны 5-р саны 24-нд батлагдсан бөгөөд хөтөлбөрийн хүрээнд нийт 314.5054 сая ЗТЭ буюу 434.3 сая ам.долларын зээлийг олгохоор анх тохирсон ([Хэвлэлийн мэдээлэл No. 17/193](#)-ыг харна уу). ОУВС-ын дэмжлэгтэйгээр хэрэгжиж буй Засгийн газрын “Эдийн засгийг сэргээх хөтөлбөр” нь эдийн засгийг тогтворжуулах, төсвийн алдагдал болон өрийг бууруулах, гадаад валютын нөөцийг нөхөн бүрдүүлэх, өсөлт-уналтын мөчлөгийн нөлөөллийг сааруулах арга хэмжээг шинээр нэвтрүүлэх, тогтвортой бөгөөд хүртээмжтэй өсөлтийг дэмжих зорилготой юм.

ОУВС-гийн Захирлуудын зөвлөлөөр хөтөлбөрийн үнэлгээг хэлэлцсэний дараа хурлын даргын үүрэг гүйцэтгэгч, тус сангийн дэд тэргүүн ноён Мицүхиро Фурусава дараах мэдэгдлийг хийв. Үүнд:

ОУВС-ын дэмжлэгтэй Монгол улсад хэрэгжиж буй хөтөлбөрийн гүйцэтгэл сайн байна. Хөтөлбөрийг сайн хэрэгжүүлж байгаа, гадаад эрэлт идэвхжсэн, итгэл сэргэж байгаа зэргээс эдийн засаг анхны хүлээлтээс илүү сайн сэргэж байна. Төсвийн орлого ихээр өсч, зардлыг хатуу хянадаг болсноор төсвийн алдагдал эрс буурч, улсын өрийн байдалд ажиглагдахуйц ахиц гарчээ. 2018 онд хугацаа нь дуусах гадаад бондыг бага хүүтэй бондоор сольсоноор гадаад санхүүжилтын зардал үргэлжлэн буурч, гадаад валютын нөөц дахин сэргэсэн байна.

2017 оны 12 дугаар сарын эцсийн байдлаар хөтөлбөрийн бүх тоон зорилтууд биелсэн. Хэдийгээр зарим нэг хазайх, удаашрах зүйл гарч байгаа ч төсөв болон банкны салбарт шинэчлэл үргэлжилсээр байна. Төсвийн зарлагыг хазаарлаж, уул уурхайн холбогдолтой орлого эргэн сэргэснээр төсвийн алдагдал ихээхэн хэмжээгээр буурч, улмаар төсвийн үр дүн хүлээгдэж байснаас мэдэгдэхүйц сайжирсан. Нүүрсний экспорт, хөрөнгийн урсгал, хандивлагч байгууллага болон ОУВС-ын гадаад санхүүжилтын багцын зарцуулалт өссөнөөс 2017 онд гадаад валютын албан нөөц хоёр дахин нэмэгдсэн.

Эрх баригчид дунд хугацаанд өсөлтийг тогтвортой барьж, эдийн засгийн өрсөлдөх чадвар болон солонгоруулалтыг дэмжин, өсөлт-уналтын мөчлөгийн нөлөөллийг сааруулахад чиглэсэн бүтцийн томоохон өөрчлөлт хийхийг зорин ажиллаж байна. Санхүүгийн салбарт саяхан хийгдэж дууссан Банкны активын чанарын үнэлгээ болон УИХ-аас баталсан хэд хэдэн хуулиуд дээр үндэслэн банкны системийг сэргээн босгох, бэхжүүлэх ажиллагаа мөн хийгдэж байна. Энэ салбарт шинэчлэлийн эрч хүчийг тогтвортой хадгалах нь туйлын чухал юм. Төсвийн хувьд эрх баригчид орлогын одоогийн өндөр түвшнийг хадгалах, зарцуулалтыг үргэлжлүүлэн хязгаарлах зэрэг засч, залруулах чигрүүгээ тууштай явж байна. Үүний тулд тэд ОУВС-ын техникийн туслалцаанд тулгуурлан татварын албаны чанарыг сайжруулахад голлон анхаарч байна.

Өрийн хэмжээ өндөр, эдийн засаг дэлхийн таваарын зах зээлээс хамааралтай үед эрх баригчид уг хөтөлбөрийг тууштай хэрэгжүүлэх нь нэн чухал. Сэргэж буй өсөлт, итгэл найдвар, өсөн нэмэгдэж буй гадаад валютын нөөц, өрийн бууралт, хандивлагч байгууллагуудын хүчтэй дэмжлэгтэй байгаа энэ мөчлөгийг хадгалахын тулд хөтөлбөрийг чанартай, сайн хэрэгжүүлэх хэрэгтэй.